

МОНГОЛ УЛС ДАХЬ ГАДААД ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ӨНӨӨГИЙН ХАНДЛАГА, ТӨЛӨВ БАЙДАЛ

Батцэнгэлийн Мөнхжаргал, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургуулийн Нийгмийн Ухааны Салбарын Эдийн засгийн тэнхмийн ахлах багш

Хураангуй

Хүн амын гадаад шилжилт хөдөлгөөний орчин үеийн түүх Монгол Улсад 1990-ээд оноос эхлэлтэй ч түүний динамик хандлага, шалтгаан, үр нөлөөг цогцоор нь судалж, холбогдох бодлого хөтөлбөрөө төлөвлөх, үнэлэх, сайжруулахад ашиглах байдал хангалтгүй явагдаж ирсэн. Энэхүү ажлаар, хүн амын хэтийн тооцоо, бодлого хөтөлбөрийн төлөвлөлт, үнэлгээ, бусад судалгааны ажлуудад дутагдсаар ирсэн Монгол Улс дахь гадаад шилжилт хөдөлгөөний агрегат тоо, түвшинг тооцож, динамик хандлагыг дүгнэхийг зорьсон. Олон улсын болон дотоодын мэдээллийн эх сурвалжуудын, шилжилт хөдөлгөөний “урсгал” болон “шилжин суурьшигчид”-ын мэдээллүүдээр сүүлийн 30 орчим жилд Монгол Улсад “байнгын” болон “түр” гадаад шилжин явагчид шилжин ирэгчдээсээ дандаа их байгаа нь бодлогын талаас хүн амаа өсгөх, шилжигчдээ эргүүлэн татах сонирхолтой Монгол Улсын хувьд анхаарал татах үзүүлэлт юм.

Түлхүүр үгс: Монгол Улсын гадаад шилжилт хөдөлгөөн, түр шилжилт хөдөлгөөн, байнгын шилжилт хөдөлгөөн, гадаад шилжилт хөдөлгөөний түвшин, цэвэр шилжилт хөдөлгөөн

Abstract

Although contemporary international migration history of Mongolia traces back to 1990s, the comprehensive study of its dynamic trends, reasons and impacts as well as application of studies in planning, monitoring and improvement of migration-related policies and programs have been inadequate. The primary objective of the study is to estimate the aggregate number and rate of international migration of Mongolia, under which the population projection, planning and monitoring of policy/programs and other research are limited and the conclusion is made on its dynamic trend. The facts of continued excess of long-term and temporary emigrants compared to immigrants during last 30 years, which were estimated based on “flow” and “stock” migration data in both international and domestic data sources, appear to be a challenge for Mongolia, as its policy interest is largely focused on population increase and returns of emigrants.

Key words: International migration of Mongolia, temporary migration, short-term migration, long-term migration, international migration rate, net migration

1. ОРШИЛ

Гадаад шилжилт хөдөлгөөн буюу хүмүүсийн байнга оршин суудаг газраа олон улсын хил даван өөрчлөх хөдөлгөөн нь хамрах хүрээ, учир шалтгаан, үзүүлэх нөлөө гэх мэт олон талаасаа улс орнуудын бодлогын анхаарлыг татсан асуудал хэвээр байна. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын мэдээллээр, гадаад шилжигчид буюу төрсөн газраасаа өөр улс оронд байнга оршин сууж байгаа, эсвэл иргэний харъяаллын хувьд өөрийн харъяаллын биш улсад байнга амьдарч буй хүмүүсийн тоо дэлхийн хэмжээнд 1970 онд 85 сая байсан

бол 2000 онд 173 сая, 2010 онд 220 сая, 2019 онд 272 сая болж, дэлхийн хүн амд эзлэх хувь 2.2 хувиас 3.5 хувь болж өсчээ (ИОМ, 2019а).

Шилжигчид “хүлээн авагч” улс орондоо эдийн засгийн болон хүн ам зүйн хувьд ихэвчлэн эерэг үр нөлөөнүүд, тухайлбал, хөдөлмөрийн нөөцийн хомсдолыг нөхөх, тодорхой үр чадвар бүхий ажиллах хүчний дутагдлыг нөхөх, ажлын байр бий болгож, татварын орлогыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, хүн амын насжилтын сөрөг үр дагавруудыг саармагжуулах, хүн амын тооны бууралтыг багасгах зэрэг үр дүнгүүд үзүүлж байна. Мөн “илгээгч” улсдаа

мөнгөн ба мөнгөн бус гуйвуулга, гадаад валютын урсгал, капиталын болон мэдлэг, ур чадварын “хөрөнгө оруулалт” авчрах, хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт эерэгээр нөлөөлөх (хөдөлмөрийн илүүдэл нийлүүлэлт багасч, цалин нэмэгдэх), ядуурлыг бууруулах, гадаад худалдааг өргөжүүлэх зэргээр микро болон макро түвшний эдийн засагт эергээр нөлөөлдөг байна (World Bank, 2019; IMF, 2009; ОУХБ, 2004; ILS, 2004). Гэхдээ зарим тохиолдолд гадагш шилжих хөдөлгөөн нь “илгээгч” орны хүн амын тоо, өсөлт, насны бүтэц, мөн боловсрол, ур чадвартай иргэдээ гадагш алдах зэрэгт таагүй нөлөө үзүүлэхээс гадна гадаадад шилжигчдийн эх орон руугаа шилжүүлдэг шилжүүлэг нь цөөн тохиолдолд хувь хүмүүсийн эдийн засгийн идэвхийг богино хугацаанд бууруулах, ажилгүйдэл, тэгш бус байдлыг нэмэгдүүлэх, шилжилт хөдөлгөөнийг улам нэмэгдүүлэх гэх мэт сөрөг нөлөөтэй байдаг (World bank, 2019; Vadean.F et.al., 2019; Justino.P & O.Shemyakina, 2012; Cohen.H, 2005).

Монгол Улсын хувьд улс төр, нийгэм, эдийн засгийн тогтолцооны онцлогоос хамааран хүн амын гадаад шилжилт хөдөлгөөн 1990-ээд оныг хүртэл харьцангуй хаалттай, бага түвшинд байсан. Харин ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойш иргэдийн гадаад шилжилт хөдөлгөөн идэвхжин, хэв маяг, онцлогийн хувьд өнөөгийн дүр төрхийг бий болгосон гэж үздэг. Гэвч Монгол Улсын хувьд гадаад шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тоо мэдээлэл 1990-ээд оноос өнөөг хүртэл хамралт, хүртээмж, чанарын хувьд нэлээд дутагдалтай явж ирсэн. Ялангуяа хүн амын гадаад шилжилт хөдөлгөөний динамик хандлага, өөрчлөлтийн мэдээлэл маш хангалтгүй байсаар ирсэн нь гадаад шилжилт хөдөлгөөний макро түвшний судалгаа шинжилгээ, үндэсний хүн амын хэтийн тооцоо, бодлого хөтөлбөрийн төлөвлөлт, үнэлгээнд хүндрэл учруулсаар байна.

Иймд энэхүү ажлаар олон улсын болон дотоодын эх үүсвэрийн хоёрдогч тоо мэдээлэл, судалгааны ажлуудад үндэслэн Монгол Улсын хүн амын гадаад шилжилт хөдөлгөөний агрегат тоо, түвшинг тогтоож, динамик хандлагыг гаргахыг зорьлоо. Динамик өөрчлөлт, хандлагын судалгаа нь гадаад шилжилт хөдөлгөөнийг бүх түвшинд гүнзгийрүүлэн судлахын өмнө зайлшгүй яригдах ёстой асуудал тул Монгол Улсын

гадаад шилжилт хөдөлгөөний судалгаа, эрдэм шинжилгээний ажлуудыг цаашид өргөжүүлэхэд энэ ажил нь бага боловч хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна.

Энэхүү ажлыг баримт бичгийн судалгааны аргаар гүйцэтгэсэн ба нийтлэгдсэн тоо, баримт бичиг, хууль, дүрэм журам, гарын авлага, судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, анхдагч эх үүсвэрүүдийн мэдээлсэн задгай тоон статистик, захиргааны буюу албан хэрэгцээнд цуглуулсан зарим мэдээ, материалыг ашигласан.

2. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Гадаад шилжилт хөдөлгөөнийг судлахад зарим ойлголт, хэмжүүрийг улс орнууд ялгаатайгаар хэрэглэх тохиолдлууд байдаг. Харин гадаад шилжилт хөдөлгөөний талаарх ойлголтуудыг жигдлэх үүднээс НҮБ-аас “Гадаад шилжих хөдөлгөөний статистикийг бэлтгэх зөвлөмж”-ийг 1998 онд гаргасан байдаг ба түүнд гадаад шилжилт хөдөлгөөн гэдэг нь хүмүүсийн байнга оршин суудаг газраа олон улсын хил даван өөрчлөх хөдөлгөөнийг хэлнэ гэжээ. *Байнга оршин суудаг улс* гэдэг нь тухайн хүний амьдарч буй улсыг, тодруулбал, тухайн хүний өдөр тутмын ажлаас гадуурх хугацаагаа өнгөрөөн амьдардаг улсыг хэлдэг. Гадаад руу амрах, аялах, найз нөхөд, хамаатныдаа зочлох, албан ажлын, эмнэлгийн үйлчилгээ авах, эсвэл шашны зан үйлийн зэрэг зорилгоор хөдөлгөөнд оролцох нь байнгын оршин суудаг улс орноо өөрчилсөн хэрэг биш гэж үздэг.

Хэмжигдэхүүн талаасаа, байршлаа сольж буй хүмүүсийг гадаад шилжилт хөдөлгөөнд оролцогч мөн эсэхийг тодорхойлох бүх нийтээр ижил хэрэглэдэг тодорхойлолт одоогоор олон улсад байхгүй байна. Улс орнууд бүртгэл, мэдээлэлдээ өөрийн сонголтоор, дараах таван төрлийн шалгуур үзүүлэлтүүдийн хэд хэдийг хангах, эсхүл аль нэгийг нь хангасан эсэхээр нь шилжигчдийг тодорхойлж байна. Үүнд:

1. Төрсөн улсаасаа өөр улс оронд амьдарсан байх/амьдрах
2. Иргэний харъяалал өөр улсад явсан/ирсэн байх
3. Байнга оршин сууж буй улсаа өөрчилсөн байх
4. Тухайн байршилд байсан/байх хугацааны

доод босго /3 сар, 6 сар, 1 жил/-ыг давсан байх

5. Тухайн байршилд ирсэн/явсан зорилго нь гадаад руу амрах, найз нөхөд хамаатныдаа зочлох, албан ажлын, эмнэлгийн үйлчилгээ авах, эсвэл шашны зан үйлийн гэх мэтээс бусад байх.

Шилжилтийн хугацаанаас нь хамааруулан гадаад шилжилт хөдөлгөөнд оролцогчдыг “байнгын буюу урт хугацааны шилжигч” (long-term migrant), “түр буюу богино хугацааны шилжигч” (short-term migrant) гэж ангилан судлах хандлага түгээмэл байна. НҮБ-ын зөвлөмжөөр, хэрэв шилжигч 1 жил, түүнээс дээш хугацаагаар байнга оршин суух улсаа өөрчилсөн бол байнгын шилжигч, харин 3 сараас дээш гэхдээ 1 хүртэл жилийн хугацаагаар өөрчилсөн бол түр шилжигч гэж үздэг (UN DESA, PD, 2012). Гэхдээ практикт зарим улс орнууд хугацааны босгыг НҮБ-ын зөвлөснөөс ялгаатайгаар хуульчлан тогтоож хэрэглэх нь ч байна. Тухайлбал, Герман улсад байнга оршин суудаг улсаа өөрчилсөн тухайн агшинаар шилжих хөдөлгөөн шууд явагдсан гэж үздэг байхад, Австрид 3 сар, Норвегид 6 сар, АНУ, Шведэд 1 жил гэх мэт хугацаагаар босго тавин шилжих хөдөлгөөнийг ялгаж байна. Монгол Улсын хувьд одоогийн баримталж буй хууль, аргачлалууд⁹-аар 183 хоногоос дээш хугацаагаар байршлаа солих хөдөлгөөнд оролцогчдыг урт хугацааны шилжих хөдөлгөөнд оролцогч гэж үзэж байна.

НҮБ-ын “Гадаад шилжилт хөдөлгөөний статистикийг бэлтгэх зөвлөмж”-д хил давах 18 төрлийн хөдөлгөөнд оролцогчдыг зорилгоор нь а) Гадаад шилжилт хөдөлгөөнд тооцогдохгүй, дамжин өнгөрөх хөдөлгөөнд оролцогчид, б) Олон улсын аялал жуулчлалд хамаарах хөдөлгөөнд оролцогчид, в) Гадаад шилжилт хөдөлгөөний статистикаас уламжлалт байдлаар хасагдаж тооцогдох хөдөлгөөнд оролцогчид, г) Гадаад шилжилт хөдөлгөөнд тооцогдох хөдөлгөөнд оролцогчид, д) Гадаад шилжилт хөдөлгөөнд тооцогдож болохоор боловч хүлээн авагч улсад байх хугацаа нь тодорхойгүй, хил нэвтрэх хөдөлгөөнд оролцогчид гэж ангилахыг зөвлөсөн байдаг (Дэлгэрэнгүйг Хавсралтаас харна уу).

Эдгээрээс, гадаад шилжилт хөдөлгөөнд оролцогчид гэдэгт, гадаадад байнга оршин суухаар шилжигч, өөрийн харъяаллын биш улсад гадаадаас цалин хөлс авч буй шилжигч ажилчид, гадаадад суралцахаар явагчид, дээрх хүмүүсийг дагалдан яваа гэр бүлийн гишүүд болон хууль, дүрэмд заагдсан бусад хүмүүсийг хамруулан авч үзэх нь судалгаануудад түгээмэл байна (IOM, 2019b). Монгол Улсын гадаад шилжилт хөдөлгөөний мэдээллийг дээрх байдлаар нарийвчлан ангилж судлах боломж одоогийн мэдээллийн эх үүсвэрүүдэд дутагдалтай байна.

Аливаа улсын гадаад шилжилт хөдөлгөөний тухай ярихад шилжилт хөдөлгөөнд оролцогчдыг тухайн улсын харъяат, харъяат бус гэж ангилан, аль алиных нь шилжилт хөдөлгөөний асуудлыг авч судлах шаардлагатай байдаг. Хэдийгээр Монгол Улсын харъяат иргэдийн гадаад руу шилжих хөдөлгөөнийг судлаачид тодорхой хэмжээгээр анхааран судалж ирсэн ч Монгол Улсад байгаа гадаадын иргэдтэй холбоотой цэгцтэй тоо мэдээлэл албан ёсны статистикуудаар гардаггүй, бусад мэдээллийн эх үүсвэрүүдээр ч маш хязгаарлагдмал судлагдсан байгаагаас¹⁰ улс орны хэмжээнд хүн амын гадаад шилжилт хөдөлгөөн цэвэр дүнгээрээ ямар нөлөө үзүүлж буйг үнэлж дүгнэхэд хүндрэлтэй байна.

Академик судлаачдын 1990-ээд оноос хойшхи Монгол Улсын иргэдийн гадаад шилжилт хөдөлгөөний асуудлыг судалсан байдлуудаас харахад, гадаад шилжилт хөдөлгөөнийг зохицуулах эрх зүйн орчин, шилжилт хөдөлгөөний удирдлагыг боловсронгуй болгох, гадаад шилжилт хөдөлгөөнд оролцогчдын хүний эрхийн байдлын хэрэгжилт зэрэг асуудлыг нэлээд судалж иржээ. Тухайлбал, Хууль зүйн үндэсний хүрээлэн (2018), Т.Цогзолмаа (2017), Х.Гэрэлчулуун (2011), Т.Солонго (2010) нар хүн амын гадаад шилжилт хөдөлгөөний талаарх олон улсын болон Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын байдлыг, С.Одмаа (2016), Н.Намуундолгион (2015), С.Жандос (2014) нар олон улсын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний удирдлагын асуудлыг магистрын зэрэг горилсон судалгааны ажлын хүрээнд судалсан байна. Тэдгээр ажлуудад гадаад шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийн эх үүсвэрүүдийг хязгаарлагдмал байдлаар ашигласан, гадаад шилжилт хөдөлгөөний тоо

⁹ Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, ҮСХ (2013)-ны хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал

¹⁰ Болормаа.Ц (2019)

мэдээллүүд нь зөрүүтэй, сэдэвтээ тохирсон тоо мэдээллүүд дутагдалтай зэрэг нийтлэг сул талууд ажиглагдаж байна.

Гадаад руу шилжих хөдөлгөөнд оролцсон монгол иргэдийн нөхцөл байдлын талаар анхдагч мэдээлэл цуглуулж, шилжигчдийн хүний эрхийн хэрэгжилтийн талаас нь дүгнэлт өгсөн түүвэр судалгаа болон хоёрдогч мэдээллүүдэд үндэслэн хийсэн судалгааны ажлууд цөөнгүй байна (Ц.Болормаа, 2019; ХХССТ, ХНХЯ, НҮБХАС, 2017; ХНХСИ, 2016а; ХНХСИ, 2016б; А.Солонго, 2012; Ц.Болормаа, 2012; А.Солонго, 2011; П.Увш, 2011; ХЭҮК, 2007; МХАХН, НҮБХАС, 2005; *Хэвлэлийн хүрээлэн ТББ, НЗХГ, 2018*). Хэдийгээр дээрх түүвэр судалгаанууд гадаад шилжилт хөдөлгөөний микро түвшний анхдагч тоо мэдээлэл бүрдүүлж, шилжигчдийн нөхцөл байдлыг нарийвчлан судалсан сайн талтай ч голчлон Монгол Улсын харъяат хүн ам, тэр дундаа хөдөлмөрийн шилжигчдийн хүрээнд, тэдний гадаадад байгаа нөхцөл байдлыг хүний эрх, аюулгүй байдлын өнцгөөс нь судалсан ба шилжилт хөдөлгөөний үр нөлөөг төдийлөн өргөн хүрээнд, гүнзгийрүүлж судлаагүй байна. Түүнчлэн дээрх судалгаануудын түүвэрлэлт нь магадлалт бус тул төлөөлөх чадвар султай, үр дүнгүүд нь дескриптив төдийгөөр хязгаарлагдсан зэрэг сул талууд байна.

Монгол Улсын иргэдийн гадаадад шилжих хөдөлгөөний үр нөлөөг үнэлэх чиглэлээр Э.Өлзийлхамын “Иргэдийн гадаад шилжих хөдөлгөөн Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь” диссертацийн ажил 2016 онд хийгдсэн байна. Гэвч Э.Өлзийлхам судалгаандаа макро түвшний тоо мэдээллээр үнэлэгдвэл зохих судалгааны асуулт, зорилго тавьсан ч тоо мэдээлэл дутагдалтайгаас төлөөлөх чадваргүй түүвэртэй микро түвшний мэдээллээр дүгнэлт хийсэн байна.

Академик ажлуудаас гадна захиргааны байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглахаар цуглуулсан зарим судалгаа, мэдээлэл байдаг ч түүвэрлэлт болон “статистик мэдээлэл бэлтгэх” талаасаа учир дутагдалтай, мөн нийтэд ил тод биш буюу албан ёсоор зарлагдаагүй байдлаар

судлаачдад олдож байна. Тухайлбал, ХНХЯ, ХНХСИ-аас 2016 онд хийсэн Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний нөхцөл байдлын судалгаа; БНСУ, Япон улсад хөдөлмөр эрхэлж буй болон эх орондоо эргэн ирсэн иргэдийн нөхцөл байдлын судалгаа; Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний өнөөгийн нөхцөл байдалд хийсэн баримт бичгийн шинжилгээ, ГХЯ-ны гадаадад байгаа монгол иргэдийн тоон мэдээллүүд, ХНХЯ-ны захиалгаар 2016 хийгдсэн Гадаад шилжих хөдөлгөөний тоон ба чанарын судалгаа зэргийг үүнд дурьдаж болно.

Гадаад шилжилт хөдөлгөөний үр нөлөөг хэмжихэд олон улсад ашигладаг нэг гол мэдээлэл бол шилжигчдийн хувийн гуйвуулга байдаг. Гадаад хувийн гуйвуулгын макро түвшний мэдээллийг 1998 оноос хойш жил, улирлаар Монголбанкны “Төлбөрийн тэнцлийн тайлан”-аар гаргаж ирсэн. Гэвч уг мэдээллийг ашиглан шилжилт хөдөлгөөний макро түвшний үр нөлөөг үнэлэхэд шилжигчдийн агрегат тоо мэдээлэл динамикаар байхгүй асуудал нь үнэлгээ, арга зүйн талаас хүндрэл үзүүлж байна. Учир нь, онолын болон эмпирик талаасаа гуйвуулгын макро түвшин дэх үр нөлөөний судалгаануудад шилжигчдийн агрегат тоо, түүхэн хандлагын мэдээлэл онцгой үүрэгтэй, чухал хувьсагч нь байдаг тул шилжигчдийн агрегат мэдээлэл динамикаар байхгүй үед судлаачдад гуйвуулгын мэдээллээр бодитой үнэлгээ хийхэд хүндрэлтэй байдаг. Иймээс ч, Монгол Улсад өнөөг хүртэл шилжигчдийн гуйвуулгын агрегат тоог ашиглан, шилжилт хөдөлгөөний үр нөлөөг үнэлэх нарийвчилсан шинжилгээнүүд хийгдээгүй байж болох юм.

Гадаад шилжилт хөдөлгөөнийг гол сэдвээ болгон судлаагүй ч түүнтэй холбоотой тоо мэдээллийг дам хамруулан цуглуулсан судалгаанууд мөн тодорхой хэмжээнд байна. Тэдгээрээс онцолбол, ҮСХ-ны гүйцэтгэсэн Хүн ам, орон сууцны тооллого болон үндэсний түвшинд төлөөлөх чадвартай түүвэр бүхий зарим түүвэр судалгаанууд байна. Гэвч өнөөг хүртэл, тэдгээрийг ашиглан гадаад шилжилт хөдөлгөөнийг нарийвчлан судалсан ажил бараг байхгүй байна.

3. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ӨНӨӨГИЙН ХАНДЛАГА, ТӨЛӨВ БАЙДАЛ

Энэ хэсэгт 1990-ээд оноос хойших Монгол Улсын хүн амын гадаад шилжилт хөдөлгөөний агрегат тоо, түвшинг НҮБ-ын болон дотоодын мэдээллийн эх үүсвэрийн тоо мэдээллүүдэд үндэслэн тооцож, харьцуулан авч үзсэн.

Шилжилт хөдөлгөөний *flow* буюу *урсгал*¹¹ мэдээлэлд үндэслэсэн Монгол Улсын гадаад шилжилт хөдөлгөөний талаарх НҮБ-ын тооцоог Хүснэгт 1-д, уг тоог Монгол Улстай төстэй нөхцөл байдал бүхий зарим орнууд болон хил залгаа ОХУ, БНХАУ-ын хүн амын гадаад шилжилт хөдөлгөөнтэй харьцуулж Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 1. НҮБ-ын тооцсон Монгол Улсын хүн амын өсөлтийн үзүүлэлтүүд, *flow* буюу урсгал мэдээллээр тооцсон гадаад шилжилтийн үзүүлэлтүүд, 1985-2020

Үзүүлэлтүүд	1985	1990	1995	2000	2005	2010	2015
	- 1990	-1995	-2000	-2005	-2010	-2015	-2020 ¹²
Хүн амын жилийн дундаж өсөлт (%)	2.56	1.02	0.85	1.05	1.48	1.95	1.78
1000 хүн ам тутам дахь жилийн дундаж ердийн цэвэр өсөлт ¹³	25.5	18.1	12.9	11.7	15.6	19.8	18.1
1000 хүн ам тутам дахь жилийн дундаж механик цэвэр өсөлт буюу гадаад цэвэр шилжилт ¹⁴	0.0	-7.89	-4.47	-1.22	-0.84	-0.30	-0.27
Жилийн дундаж гадаад цэвэр шилжилтийн тоо ¹⁵	0	-88,432	-52,463	-15,001	-10,998	-4,262	-4,262

Эх сурвалж: United Nations, Department of Economic and Social Affairs, Population Division (2019). World Population Prospects 2019 (<https://population.un.org/wpp/DataQuery/>)

Хүснэгт 1-ээс харахад, 1990 оноос хойш Монгол Улс дахь тус улсын харъяат ба харъяат бус хүн амын гадаадад шилжин явсан тоо нь гадаадаас тус улсад шилжин ирсэн тооноос дандаа илүү байна. Түвшингээр харвал, 1990-ээс 2000 оныг хүртэл гадаад шилжилт хөдөлгөөний түвшин хамгийн өндөр, ялангуяа 1990-1995 онд Монгол Улсын хүн амын тоо гадаад шилжилт хөдөлгөөнөөс болж 1000 хүн тутамд 8 орчим хүнээр буурч байжээ. Харин 2000-аад оны дундаас гадаад цэвэр шилжилт хөдөлгөөний хүн амын өсөлтөд үзүүлсэн сөрөг нөлөө харьцангуй удааширсан ч сөрөг хэвээр байна.

Ази болон Зүүн Европ тивийн, далайд гарцгүй, өмнө нь социалист тогтолцоотой байсан, хүн ам харьцангуй цөөнтэй, эдийн засгийн хэмжээ

бага, сүүлийн жилүүдэд эдийн засаг нь өсч байгаа, уул уурхайд тулгуурласан эдийн засагтай зарим орнуудын хүн амын гадаад шилжилт хөдөлгөөний хандлагыг харахад, ерөнхийдөө 1990-ээд оны эхэн үеэс 2000-аад оны дунд үе хүртэл хөдөлгөөн харьцангуй өндөр түвшинтэй, дандаа гадагшаа шилжин явсан хөдөлгөөн нь ирэх хөдөлгөөнөөс их байсан нийтлэг хандлага ажиглагдаж байна. Үүнээс хойш 1000 хүнд ногдох гадаад цэвэр шилжилтийн түвшин багасаж байгаа ч “сөрөг утгатай” хэвээр байна. Харин Монгол Улстай хил залгаа хоёр орны хувьд 1990-ээд оноос хойш гадаад цэвэр шилжилт хөдөлгөөний түвшин харьцангуй хэлбэлзэл багатай, ОХУ-д “эерэг утгатай” буюу шилжин ирэлт нь явалтаасаа их, БНХАУ-д “сөрөг утгатай”

¹¹ НҮБ-ын тодорхойлолтоор, шилжих хөдөлгөөний *flow* буюу *урсгал* гэдэг нь хилээр орох, гарах хоёр хөдөлгөөнийг багтаах ба авч үзэж буй хугацааны турш тодорхой улсад орж ирсэн шилжигчдийн тоог *орох урсгал* (inflows or immigrants), ижил хугацааны турш тухайн улсаас гарсан шилжигчдийн тоог *гарах урсгал* (outflows or emigrants) гэнэ.

¹² НҮБ-аас хийсэн хэтийн тооцоо.

¹³ Авч үзэж буй хугацаанд бүртгэгдсэн нийт төрөлт ба нас баралтын зөрүүг жилийн дундаж хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлт.

¹⁴ Авч үзэж буй хугацаанд бүртгэгдсэн нийт шилжин ирэгчдээс шилжин явагчдыг хассан зөрүүг жилийн дундаж хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлт.

¹⁵ Монгол Улсын харъяат ба харъяат бус иргэдийн шилжих хөдөлгөөнүүдийг оролцуулан тооцсон ба Монголд шилжин ирэгчдийн тооноос шилжин явагчдын тоог хассан дүн.

буюу шилжин явалт нь ирэлтээсээ их байна. ОХУ-ын хувьд, хуучин ЗХУ-ын харъяанд байсан олон орнуудаас шилжигчид ихээхэн очдог орон юм. Ерөнхийдөө, урсгал буюу flow мэдээлэлд үндэслэсэн тооцоонууд Монгол

Улсын хүн амын гадаад шилжилт хөдөлгөөний динамик хандлага ижил төстэй нөхцөл байдал бүхий улс орнуудынхтай төстэй хандлагаар өөрчлөгдөж буйг харуулж байна.

Хүснэгт 2. Сонгосон орнуудын гадаад цэвэр шилжилтийн тоо ба 1000 хүн амд ногдох гадаад цэвэр шилжилтийн түвшин, 1985-2020

Улсын нэр	Хүн ам (000), 2020	1985 - 1990	1990 -1995	1995 -2000	2000 -2005	2005 -2010	2010 -2015	2015 -2020*
Монгол	3,278	0 (0.0)	-88,432 (-7.9)	-52,463 (-4.5)	-15,001 (-1.2)	-10,998 (-0.8)	-4,262 (-0.30)	-4,262 (-0.3)
Гүрж	3,989	-43,659 (-1.6)	-591,854 (-22.8)	-653,597 (-28.0)	-148,337 (-6.9)	-119,811 (-5.8)	-95,340 (-4.7)	-50,000 (-2.5)
Армени	2,963	-	-496,288 (-3.9)	-223,873 (-29.4)	-160,521 (-14.2)	-183,361 (-10.6)	-30,535 (-12.5)	-24,989 (-2.1)
Киргызстан	6,524	-126,883 (-6.1)	-276,249 (-12.4)	-27,268 (-1.2)	-172,911 (-6.9)	-76,604 (-2.9)	-93,353 (-3.3)	-20,000 (-0.6)
Тажикистан	9,538	-31,508 (-1.3)	-232,301 (-8.4)	-237,255 (-7.9)	-144,939 (-4.5)	-145,788 (-4.1)	-136,974 (-3.4)	-99,999 (-2.2)
Туркменистан	6,031	-39,702 (-2.3)	+43,633 (+2.2)	-64,674 (-3.0)	-125,883 (-5.4)	-62,717 (-2.5)	-50,002 (-1.9)	-25,001 (-0.9)
Казахстан	18,777	-674,287 (-8.4)	-1,143,396 (-17.9)	-1,261,512 (-16.4)	+44,530 (+0.6)	-35,196 (-0.4)	+159,807 (+1.9)	-90,000 (-1.0)
Узбекистан	33,469	-356,031 (-3.7)	-322,777 (-3.0)	-242,636 (-2.0)	-242,297 (-1.9)	-140,130 (-1.0)	-66,469 (-0.4)	-44,314 (-0.3)
Лаос (БНАЛАУ)	7,276	-138 (0.0)	-60,567 (-2.7)	-134,746 (-5.3)	-148,100 (-5.3)	-110,258 (-3.7)	-112,313 (-3.5)	-73,518 (-2.1)
Болгар	6,948	-184,143 (-4.1)	-356,464 (-8.3)	-133,824 (-3.3)	-85,500 (-2.2)	-83,742 (-2.2)	-24,472 (-0.7)	-24,001 (-0.7)
Молдов	4,034	-84,531 (-3.9)	-13,1953 (-6.1)	-165,309 (-7.7)	-12,079 (-0.6)	-47,911 (-2.3)	-7,020 (-0.3)	-6,935 (-0.3)
ОХУ	145,934	+890,253 (+1.2)	+2,490,121 (+3.4)	+2,374,657 (+3.2)	+1,778,101 (+2.5)	+2,326,672 (+3.2)	+1,800,600 (+2.5)	+912,279 (+1.3)
БНХАУ	1,439,324	-431,651 (-0.1)	-779,982 (-0.1)	-382,999 (-0.1)	-1,965,578 (-0.3)	-2,178,385 (-0.3)	-1,552,209 (-0.2)	-1,741,996 (-0.2)

Тэмдэглэл: 1000 хүн амд ногдох гадаад цэвэр шилжилтийн түвшинг хаалтад харуулсан.

*НҮБ-ын хэтийн тооцоо; Хүн амын тоо нь de facto буюу бэлэн хүн амын жилийн дундаж тоо.

Эх сурвалж: United Nations, Department of Economic and Social Affairs, Population Division (2019). World Population Prospects 2019 (<https://population.un.org/wpp/DataQuery/>);

Дэлхийн банкны мэдээллийн сан (<https://data.worldbank.org/indicator/SM.POP.NETM?>)

НҮБ-аас улс орнуудын бүртгэл болон тооллогын мэдээлэлд үндэслэн тухайн оронд шилжин суурьшсан гадаад иргэдийн тоо буюу *international migration stock*¹⁶ мэдээллийг

сүүлийн үед тогтмол тооцон мэдээлэх болсон. Уг үзүүлэлтээр Монгол Улсын гадаад шилжилт хөдөлгөөн ямар байгааг Хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3. НҮБ-ын Stock мэдээллээр тооцсон Монгол Улс дахь гадаадын харъяат иргэд, гадаад дахь Монгол Улсын харъяат иргэд, гадаад цэвэр шилжилт, 1990-2019

Үзүүлэлтүүд	Он						
	1990	1995	2000	2005	2010	2015	2019
Монгол Улс дахь гадаадын харъяат иргэд:							
Байнга оршин суугаа гадаадын харъяат хүн амын тоо	6,718	7,424	8,206	11,477	16,062	19,886	21,128
Нийт хүн амд эзлэх хувь	0.32	0.33	0.34	0.45	0.59	0.66	0.65
Гадаад дахь Монгол Улсын харъяат иргэд:							
Гадаадад байнга оршин суугаа Монгол Улсын харъяат хүн амын тоо	24,466	27,694	30,649	42,378	57,766	66,861	73,488
Нийт хүн амд эзлэх хувь	1.12	1.21	1.28	1.67	2.11	2.21	2.24
Stock мэдээллээр тооцсон гадаад шилжилт:							
Гадаад цэвэр шилжилтийн тоо	-7,748	-20,270	-22,443	-30,901	-41,704	-46,975	-52,360
1000 хүн амд ногдох гадаад цэвэр шилжилт	-8.46	-9.11	-9.40	-12.18	-15.23	-15.52	-16.02
Гадаадад байнга оршин суугаа Монгол Улсын харъяат ба Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын харъяат хүн амын тооны харьцаа	3.64	3.73	3.73	3.69	3.60	3.36	3.48

Тэмдэглэл: Хүн амд эзлэх хувь, 1000 хүн амд ногдох үзүүлэлтийн тооцоонуудад тухайн оны жилийн дундаж, Монгол Улсын харъяат хүн амын тоог ашигласан; Гадаад цэвэр шилжилтийг Монгол Улс дахь гадаадын харъяат ба Гадаад дахь Монгол Улсын харъяат хүн амын тооны зөрүүгээр тооцсон.

Эх сурвалж: United Nations, Department of Economic and Social Affairs, Population Division (2019); International Migrant Stock 2019 (United Nations database, POP/DB/MIG/Stock/Rev.2019); www.1212.mn мэдээлэлд үндэслэсэн өөрийн тооцоо

НҮБ-ын stock мэдээлэлд үндэслэсэн тооцооллоор, Монгол Улсаас гадаадад байнга оршин сууж байгаа бүртгэлтэй Монгол иргэдийн тоо Монгол Улсад байнга оршин сууж байгаа бүртгэлтэй гадаадын иргэдийн тооноос 3.4-3.7 дахин буюу 17,748-аас 52,360 хүнээр олон байгаа хандлага 1990 оноос хойш өнөөг хүртэл харагдаж байна. Монгол Улсад байнга оршин сууж байгаа бүртгэлтэй гадаадын иргэдийн тоо 1990 оноос 2019 оны хооронд 6,718-аас 21,128 болж тасралтгүй өссөн ч Монгол Улсын нийт суурин хүн амын 0.66 хувиас илүү гарч байсан удаагүй байна.

Харин гадаадад байнга оршин сууж байгаа бүртгэлтэй монгол иргэдийн тоо мөн 1990 оноос хойш тасралтгүй өсч, 2019 онд 73,488 болсон нь Монгол Улсын нийт суурин хүн амын 2.24 хувьтай тэнцэх хэмжээнд хүрчээ. Гэхдээ энэ тоонууд нь зөвхөн бүртгэлтэй хүмүүсийн тоо бөгөөд бүртгэлгүйгээр гадаадад амьдарч байгаа хүмүүсийг тооцвол гадаад шилжилт хөдөлгөөнд оролцогчийн тоо дор хаяж 30 орчим хувиар илүү өндөр байх боломжтой юм¹⁷.

¹⁶ НҮБ-ын тодорхойлолтоор, *stock* буюу *шилжин суурьшигчид* гэдэг нь тодорхой хугацаа (жилийн эцэс, улирлын эцэс гэх мэт)-ны мөчид судалж буй улсад оршин суугаа "байнга оршин суудаг улсаа өөрчилсөн" гадаад иргэдийн нийт тоог хэлнэ. Улс орнуудад энэ үзүүлэлтийг хэмжихдээ, заагдсан хугацааны шалгуураас дээш хугацаагаар төрснөөсөө өөр улсад амьдарч байгаа хүн (гадаадад төрсөн хүн)-ий тоо, эсвэл амьдарч байгаа улсынхаасаа өөр иргэний харьяалалтай хүн (гадаадын харъяат хүн)-ий тоогоор хэмжих нь түгээмэл байдаг.

¹⁷ Гадаадад байгаа монгол иргэдийн дунд тухайн улсдаа албан ёсны амьдрах зөвшөөрөлгүй буюу хууль бусаар оршин суугаа иргэдийн хувь МХАХН, НҮБХАС (2005)-ын түүвэр судалгаагаар нийт түүвэр (n=18+ насны 694 хүн)-ийн 36.7 хувь, Солонго.А (2012)-ын судалгаагаар 31.5 хувь (n=764 хүн), ХХССТ, НҮБХАС (2017)-ын судалгаагаар 23.7 хувь (n=608 хүн) байсан. Мөн ГХЯ-ны хилийн чанад дахь консулын төлөөлөгчийн газруудын бүртгэлээр 2016/12/01 байдлаар нийт гадаад дахь 144566 монгол иргэдийн 40114 буюу 27.75 хувь нь хууль бусаар оршин суугаа гэсэн мэдээ байна.

Дотоодын мэдээллийн эх үүсвэрүүдээрх гадаад шилжилт хөдөлгөөний stock мэдээллийг Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 4. Дотоодын эх үүсвэрийн Stock мэдээллээр тооцсон Монгол Улс дахь гадаадын харъяат иргэд, гадаад дахь Монгол Улсын харъяат иргэд, гадаад цэвэр шилжилт, 1989-2020

Үзүүлэлтүүд	Мэдээллийн эх сурвалж	Он				
		1989	2000	2010	2015	2020
Монгол Улс дахь гадаадын харъяат иргэд:						
6+ сараар Монгол Улсад оршин суугаа гадаадын харъяат, харъяалалгүй хүн ам	ҮСХ, ХАОСТ	56.7 (000)	8,128	16,428 (2010/01)	19,887	22,455 (2020/01)
	ГИХГ	б/г	б/г	22,187	38,424	б/г
Нийт хүн амд эзлэх хувь	ҮСХ, ХАОСТ	2.70	0.34	0.60	0.66	0.68
Гадаад дахь Монгол Улсын харъяат иргэд:						
6+ сараар гадаадад оршин суугаа Монгол Улсын харъяат хүн ам	ҮСХ, ХАОСТ	б/г	б/г	107,140	87,423	122,301
	ГХЯ-ны бүртгэл	б/г	б/г	б/г	144,566 (2016/12)	175,687 (2018/06)
Нийт хүн амд эзлэх хувь	ҮСХ, ХАОСТ	б/г	б/г	3.91	2.89	3.71
Stock мэдээллээр тооцсон гадаад шилжилт						
Тооцоолсон гадаад цэвэр шилжилт		б/г	б/г	-90,712	-67,536	-99,846
1000 хүн амд ногдох гадаад цэвэр шилжилт		б/г	б/г	-33.1	-22.3	-30.3
Гадаадад байнга оршин суугаа Монгол Улсын харъяат ба Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын харъяат хүн амын тооны харьцаа	ҮСХ, ХАОСТ	б/г	б/г	6.5	4.4	5.5

Тэмдэглэл: б/г-мэдээлэл байхгүй; Хүн амд эзлэх хувь, 1000 хүн амд ногдох үзүүлэлтийн тооцоонуудад тухайн оны жилийн дундаж хүн амын тоог ашигласан. Гадаад цэвэр шилжилтийг Монгол Улс дахь гадаадын харъяат ба Гадаад дахь Монгол Улсын харъяат хүн амын тооны зөрүүгээр тооцсон.

Гадаадад байгаа Монгол Улсын иргэдийн суурин хүн амд эзлэх хувь 2010 оны үндэсний ХАОСТ-оор 3.91 хувь, 2020 оны тооллогоор 3.71 хувь, ГХЯ-ны мэдээлэлд суурилсан тооцоогоор 2016 онд 4.7 хувь байгаа нь дэлхийн дундаж (2019 онд дэлхийн нийт хүн амын 3.5 хувь нь гадаад шилжилт хөдөлгөөнд оролцогч байсан¹⁸)-аас өндөр байна. Өрхийн хувьд авч үзвэл, ХАОСТ-2010-аар гадаадад байнга оршин сууж буй хүнтэй өрх 40,388 тоологдсон буюу Монгол Улсын нийт өрхийн 5.6 хувийг эзэлж байгаа үр дүн гарчээ. Монгол Улсаас гадаадад шилжин суурьшиж буй хүн гадаадаас Монгол Улсад шилжин суурьших хүн амаас 2010 онд 6.5 дахин, 2020 онд 5.5 дахин олон байгаагийн улмаас сүүлийн тооллогын онуудад цэвэр дүнгээрээ бэлэн хүн амын тоо 1000 хүн тутамд 30-33 хүнээр цөөрсөн байна.

Гадаад шилжилт хөдөлгөөний хандлагыг дотоодын мэдээллийн эх үүсвэрийн урсгал буюу flow мэдээллээр тооцоход Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ)-аас гаргасан иргэдийн хилээр орсон, гарсан урсгал хөдөлгөөний мэдээлэл¹⁹-ийг ашиглаж болохоор байна. Уг мэдээллээс, 1995 онд давхардсан тоогоор хилээр нийт 527,788 гадаад, дотоодын зорчигч орж, 532,726 зорчигч гарч байсан бол энэ тоо 2019 оны эцэст орох чиглэлд 5.77 дахин нэмэгдэж 3,043,503 хүн, гарах чиглэлд 5.73 дахин нэмэгдэж 3,052,940 хүн болсон байна. Цэвэр дүнгээрээ гадагш чиглэсэн хөдөлгөөн орох хөдөлгөөнөөс жил бүр илүү байсаар иржээ. Хилийн бүртгэлийн дээрх тоонууд нь иргэдийн гадаад шилжилт хөдөлгөөн болон шилжилт хөдөлгөөнд хамаарахгүй

¹⁸ IOM (2019a).

¹⁹ ХХЕГ-ын хилээр нэвтэрсэн иргэдийн мэдээллийг 1995 оноос хойш ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн санд байршуулсан ч гадаадын зорчигчдын тоог монгол зорчигчдоос ялгаж мэдээлэх боломж 1999 оноос л гарсан байна.

хөдөлгөөнүүд²⁰-ийг нийлүүлсэн байдлаар харуулж байгаа тул шилжилт хөдөлгөөний талаар дүгнэхэд хангалтгүй юм. Иймд, хилээр нэвтэрсэн нийт иргэдийн мэдээллээс НҮБ-ын зөвлөсөн хэмжүүрээр “гадаад шилжилт

хөдөлгөөнд оролцогчид”-ын тоог ялган Хүснэгт 5-д харуулав. Мөн уг тоогоор 1000 хүн амд ногдох гадаад шилжилт хөдөлгөөний ирэх, явах, цэвэр түвшинг тооцож Зураг 1-д харуулав.

Хүснэгт 5. Монгол Улсын хилээр нэвтэрсэн иргэдийн мэдээллээс тооцсон гадаад шилжилт хөдөлгөөнд оролцогчдын тоо, 1999-2019

Он	Шилжилтийн хугацааны мэдээлэлд үндэслэн тооцсон гадаадад шилжин явагчдын тоо	Шилжилтийн зорилго ²¹ -ын мэдээлэлд үндэслэн тооцсон гадаадад шилжин явагчдын тоо		Шилжилтийн зорилгын мэдээлэлд үндэслэн тооцсон гадаадаас шилжин ирэгчдийн тоо		Гадаад цэвэр шилжилтийн тоо (шилжин ирэлт-шилжин явалт)	
	90-с дээш хоногоор зорчихоор хилээр гарсан Монгол иргэд	Байнга оршин суух/ суралцахаар хилээр гарсан Монгол иргэд	Ажиллахаар хилээр гарсан монгол иргэд	Байнга оршин суух/ суралцахаар хилээр орсон гадаад иргэд	Ажиллахаар хилээр орсон гадаадын иргэд	Байнга оршин суух, суралцах зорилготой	Ажиллах зорилготой
1999	9,906	6,235	б/г	б/г	б/г	б/г	б/г
2000	10,613	7,640	б/г	б/г	б/г	б/г	б/г
2001	12,931	10,402	б/г	б/г	б/г	б/г	б/г
2002	12,830	7,711	б/г	б/г	б/г	б/г	б/г
2003	11,907	11,633	б/г	б/г	б/г	б/г	б/г
2004	18,150	17,812	б/г	б/г	б/г	б/г	б/г
2005	31,485	17,568	б/г	б/г	б/г	б/г	б/г
2006	30,111	18,960	б/г	4,001	б/г	-14,959	б/г
2007	24,618	21,387	б/г	2,974	б/г	-18,413	б/г
2008	18,642	20,874	б/г	3,384	19,011	-17,490	б/г
2009	25,297	22,908	2,599	4,220	46,138	-18,688	43,539
2010	30,683	38,710	5,695	3,706	97,695	-35,004	92,000
2011	32,655	29,779	37,230	3,218	163,429	-26,561	126,199
2012	33,966	33,253	46,845	6,151	141,796	-27,102	94,951
2013	34,362	33,683	65,533	3,800	93,590	-29,883	28,057
2014	31,658	33,309	118,600	4,682	108,160	-28,627	-10,440
2015	19,738	21,468	136,317	6,461	74,566	-15,007	-61,751
2016	35,404	31,812	304,757	9,589	57,490	-22,223	-247,267
2017	37,605	38,040	422,677	12,263	61,131	-25,777	-361,546
2018	42,418	42,305	418,290	14,662	54,374	-27,643	-363,916
2019	47,645	47,431	401,622	18,268	41,392	-29,163	-360,230

Тэмдэглэл: б/г -анхдагч эх үүсвэрээр мэдээлэл байхгүй; Өмнө нь гадаадад шилжсэн/гадаадад төрсөн Монгол Улсын харъяат иргэдийн Монголдоо байнга оршин суухаар буцаж ирсэн болон Монголд байнга амьдарч байсан гадаадын харъяат иргэдийн эх орон руугаа байнга оршин суухаар буцаж буй хөдөлгөөнийг хилээр орсон, гарсан нийт зорчигчдын мэдээллээс ялгах боломжгүй байгаа тул гадаадаас шилжин ирэлт ба шилжин явалтын тооцоонд тусгаагүй. Өөрөөр хэлбэл, гадаад шилжилт хөдөлгөөнд оролцогчдын тоонууд мэдээллийн боломжгүй байдлаас хамааран дутуу хамралттай гэсэн үг.

Эх сурвалж: *ҮСХ-ны мэдээллийн нээгдсэн сан (www.1212.mn)-ийн статистик мэдээлэлд үндэслэсэн өөрийн тооцоо.*

²⁰ Гэр бүл, найз нөхдийнд зочлох, амралтын, албан ажил/ томилолтын, эмнэлгийн үйлчилгээ авахаар, эсвэл шашны зан үйлийн гэх мэт зорилгоор гадаадад явах; жуулчлах; хугацааны хувьд 3 сар хүрэхгүй хугацаагаар гадаадад явах; хилээр дамжин өнгөрөх зэргийг ойлгоно.

²¹ НҮБ болон Монгол Улсад баримталж буй тодорхойлолтын дагуу ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн нь байнга оршин суух, суралцах зэрэг зорилготой шилжих хөдөлгөөнүүдээс хугацааны хувьд богино тул жилдээ дахин давтагдах боломжтой үзэгдэл. Иймд, хилийн бүртгэлийн тоонд жилдээ 1 иргэний хэд хэдэн удаа хийсэн богино хугацааны шилжих хөдөлгөөнүүд тохиолдлынхоо тоогоор давхардан бүртгэгдсэн байх боломжтой.


Хүснэгт 5 дахь Монгол Улсын хилээр нэвтэрсэн урт хугацааны шилжилт хөдөлгөөний цэвэр дүнг харахад, уг мэдээллийг бэлтгэх боломжтой болсон 2006 оноос хойш үргэлж “хасах утгатай” байна. Өөрөөр хэлбэл, жил бүр хилээр байнга оршин суух болон суралцах зорилгоор орсоноос ойролцоогоор 15-35 мянгаар илүү тооны иргэд адил зорилгоор гадагшаа гарчээ.

Сүүлийн 4 жилийн тухайд энэ тоо тасралтгүй нэмэгдэж, 2019 онд “-29,163” хүрсэн байна. Богино хугацааны гадаад шилжилт хөдөлгөөн буюу ажиллах хүчний шилжилтийн хувьд, тоо мэдээлэл 2009 оноос гарах боломжтой болсон. Ажиллах хүчний шилжилтийн цэвэр тоо²² нь Монгол Улсын эдийн засаг сэргэж, өндөр өсөлттэй байсан 2010-аас 2013 онуудад “нэмэх утгатай” буюу гадаадаас шилжин ирэх хандлага их, харин эдийн засгийн өсөлт саарч, улмаар доогуур түвшинд хүрсэн 2014 оноос

хойш “хасах утгатай” буюу гадагш чиглэсэн хөдөлгөөн орох хөдөлгөөнөөс илүү болжээ. Ялангуяа 2016-2019 онуудад давхардсан тоогоор жил бүр орж ирснээс 247,267-оос 363,916-аар илүү тооны ажиллах хүч гадаадад ажиллахаар гарсныг хилийн бүртгэлийн тоо харуулж байна.

Түвшингээр нь харвал (Зураг 1), 2006 оноос хойш жил бүр 1000 хүн ам тутам дахь гадаад руу чиглэсэн “байнгын” шилжин явах хөдөлгөөн нь “байнгын” шилжин ирэх хөдөлгөөнөөс 5-13 хүнээр их байсан (дундажлан тооцвол, жилдээ дунджаар гадаадаас шилжин ирж байгаа 1 хүн тутмын цаана 6 хүн гадаад руу шилжин явсан) нь хүн амын тоонд сөрөг нөлөө үзүүлж иржээ. Хэрэв “түр” шилжилт хөдөлгөөн буюу ажиллах хүчний шилжилтийг оролцуулбал “сөрөг” гадаад шилжилтийн түвшин бүр ч өндрөөр тооцогдох боломжтой.

Зураг 1. Шилжих хөдөлгөөний урсгалын мэдээллээс тооцсон гадаад шилжилт хөдөлгөөний түвшин (1000 хүн амд ногдох), Монгол Улс, 1999-2019



Тэмдэглэл: ГШЯК-1 нь 90-ээс дээш хоногоор гадаадад зорчихоор явсан монгол иргэдийн тоогоор тооцсон шилжин явалтын коэффициент; ГШЯК нь гадаадад байнга оршин суухаар, суралцахаар явсан монгол иргэдийн тоогоор тооцсон шилжин явалтын коэффициент; ГШИК нь гадаадаас Монгол Улсад байнга оршин суухаар, суралцахаар ирсэн гадаадын иргэдийн нийт тоогоор тооцсон шилжин ирэлтийн коэффициент; гадаад цэвэр шилжилтийн коэффициент=ГШИК-ГШЯК. Шилжилтийн коэффициентүүдийн тооцоонд Монгол Улсад оршин суугаа жилийн дундаж хүн амын тоог ашигласан.

Эх сурвалж: *ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сан (www.1212.mn) дахь ХХЕГ-ын хилээр нэвтэрсэн иргэдийн тооны статистик мэдээлэлд үндэслэсэн өөрийн тооцоолол.*

²² ХХЕГ-ын мэдээллээр, хилээр нэвтэрсэн иргэдийн хөдөлгөөнийг зорилгоор нь ангилахдаа албан ажлаар; хувийн журмаар; жуулчлахаар, хилээр дамжин өнгөрөхөөр; ажил эрхлэхээр; суралцахаар; байнга оршин суухаар; бусад гэж ангилдаг.

Дотоодын болон олон улсын мэдээллийн эх үүсвэрүүдээр тооцсон гадаад цэвэр шилжилт хөдөлгөөний жилийн дундаж үзүүлэлтүүдийг нэгтгэн *Хүснэгт 6-д харуулав.*

Дотоодын эх сурвалжийн flow мэдээллээр тооцсон “байнгын” шилжилт хөдөлгөөний цэвэр дүн НҮБ-ын эх сурвалжийнхаас 2006-2010 оны үед 1.9 дахин, 2011-2015 оны үед

6 дахин, 2016-2020 оны үед 6.1 дахин өндөр дүнтэй байгаа ч гадагшаа гарах урсгал нь орох урсгалаас илүү байгаа хандлага хоёр төрлийн эх үүсвэрт адил байна. Иймд, дотоодын болон олон улсын мэдээллийн сурвалжууд, шилжилт хөдөлгөөний flow болон stock төрлийн мэдээллүүд бүгд Монгол Улс бол 1990 оноос хойш гадаад шилжилт хөдөлгөөний хувьд “илгээгч” улс байсаар ирснийг харуулж байна.

Хүснэгт 6. Монгол Улсын жилийн дундаж гадаад цэвэр шилжилтийн тоо, мэдээллийн эх үүсвэрүүдээр

Он	Гадаад шилжилт хөдөлгөөний мэдээллийн эх үүсвэр				Дотоодын ба олон улсын эх үүсвэрийн мэдээллээр тооцсон үзүүлэлтийн зөрүү (харьцаагаар)	
	Улсын хилээр байнга оршин суух/суралцахаар нэвтэрсэн иргэдийн бүртгэл	МУ-ын ХАОСТ	НҮБ-ын Хүн амын хэлтсийн мэдээлэл			
	flow	stock	flow	stock	flow	stock
[Мэдээллийн төрөл]	[3]	[2]	[4]	[5]	[3]/[4]	[2]/[5]
1986-1990	м/б	м/б	0	-7,748	м/б	м/б
1991-1995	м/б	м/б	-88,432	-20,270	м/б	м/б
1996-2000	м/б	м/б	-52,463	-22,443	м/б	м/б
2001-2005	м/б	м/б	-15,001	-30,901	м/б	м/б
2006-2010	-20911	-90712*	-10,998	-41,704	1.9	2.2
2011-2015	-25436	-67536*	-4,262	-46,975	6.0	1.4
2016-2020	-26202	-99846*	-4,262	-52,360	6.1	1.9

Тэмдэглэл: м/б-мэдээлэл боломжгүй. Дотоодын ба олон улсын эх үүсвэрийн мэдээллээр коэффициент тооцохдоо суурь хүн амын тоог адилаар буюу тухайн оны жилийн дундаж, Монгол Улсын харьяат хүн амын тоогоор авсан.

Эх сурвалж: Өөрийн тооцоо; *2010, 2015, 2020 оны тооллогын оны тоо

Монгол иргэд эдийн засгийн буюу хөдөлмөр эрхлэх, мөн суралцах, гэр бүлээ дагалдан, байнга оршин суухаар зэрэг зорилгоор голчлон гадаад руу шилжилт хөдөлгөөнд оролцож байна (ҮСХ, 2011б; ҮСХ, 2020). Тухайлбал, ХАОСТ-оор ажил эрхлэх (хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, хувиараа ажиллах, албан томилолтоор) зорилгоор шилжин явагчид 2010 онд гадаадад оршин суугаа иргэдийн 41.3 хувь, 2020 онд 31.7 хувь, суралцахаар шилжин явагчид 2010 онд 37.0 хувь, 2020 онд 46.7 хувь байжээ. Мөн ХХССТ, ХНХЯ, НҮБХАС (2017) судалгаагаар 47.1 хувь нь ажил эрхлэхээр, 38.7 хувь нь суралцахаар явсан гэсэн байна. Шилжигчдийн шинж байдлын хувьд, ихэнх нь хөдөлмөрийн буюу 15-59 насны²³,

боловсрол өндөртэй²⁴ хүмүүс байна. Мөн 2010 оны ХАОСТ-оор гадаадад байгаа дөрвөн монгол иргэн тутмын нэг нь 6, түүнээс олон жил, 2020 оны ХАОСТ-оор гурван монгол иргэн тутмын нэг нь 5, түүнээс олон жил гадаадад амьдарч байгаа гэж тоологджээ. Ийнхүү хөдөлмөрийн насны, боловсрол өндөртэй иргэд ихэвчлэн гадаадад урт хугацаагаар шилжин явж байгаа нь Монгол Улсад “оюуны гадагшлах урсгал” явагдаж буйн шинж тэмдэг байж болох юм.

Сүүлийн хоёр удаагийн ХАОСТ-оор Монгол Улсаас иргэдийн гадаад руу шилжих хөдөлгөөний гол коридор үүсгэж буй улсууд нь сүүлийн 10 гаруй жилд БНСУ, АНУ, Япон, Чех зэрэг улсуудтай холбогдож байна (Хүснэгт 7).

²³ НҮБ-ын мэдээллийн эх сурвалжаар, нийт гадаадад оршин сууж буй иргэдийн дундах 15-59 насны хүмүүсийн хувь 1990 онд 77.3 хувь байсан бол тасралтгүй өссөөр 2019 онд 87.3 хувь болсон; ХАОСТ-оор 2010 онд 88.9 хувь; 2015 онд 87.8 хувь, 2020 онд 85.8 хувь байна.

²⁴ Техник мэргэжлийн болон түүнээс дээш түвшний боловсролтой шилжигчдийн хувь 2010 оны ХАОСТ-оор 10+ насны шилжигчдийн 54.5 хувь, МХАХН, НХХЯ, НҮБХАС (2005) судалгаагаар 18+ насны шилжигчдийн 58.3 хувь, ХХССТ, ХНХЯ, НҮБХАС (2017) судалгаагаар 18+ насны шилжигчдийн 86.6 хувь байсан.

Хүснэгт 7. Монгол Улсын иргэд хамгийн ихээр шилжин суурьшиж буй 10 улс, эзлэх хувиар

Эрэмбэ	ОУБ-ын мэдээлийн эх сурвалжаар:				Дотоодын мэдээллийн эх сурвалжаар:					
	2013		2017		2010		2016		2020	
	Улс	Шил- жигч- дийн %	Улс	Шил- жигч- дийн %	Улс	Шил- жигч- дийн %	Улс	Шил- жигч- дийн %	Улс	Шил- жигч- дийн %
1.	БНСУ	36.3	БНСУ	33.4	БНСУ	27.6	БНСУ	22.7	БНСУ	32.7
2.	ОХУ	27.4	ОХУ	26.0	АНУ	15.9	АНУ	17.3	АНУ	15.7
3.	БНЧУ	7.5	БНЧУ	7.0	БНЧУ	6.8	Казахстан	10.4	Япон	7.2
4.	БНХАУ	6.1	БНХАУ	5.6	БНХАУ	6.8	БНХАУ	6.0	Казахстан	5.9
5.	Украйн	5.9	Украйн	5.4	Япон	5.0	Япон	4.6	БНЧУ	4.9
6.	Цвед	2.8	Цвед	3.2	ОХУ	4.7	БНЧУ	4.4	Австрали	4.5
7.	Австри	2.4	Австри	2.6	ХБНГУ	3.6	Цвед	4.2	Хятад	4.2
8.	Унгар	1.8	Австрали	2.6	Англи	3.5	Канад	3.8	Герман	3.3
9.	Франц	1.7	Англи	1.8	Франц	2.7	ОХУ	3.4	Швед	3.2
10.	Австрали	1.1	Франц	1.8	Турк	2.5	Франц	3.2	Франц	2.5
Бүгд		56.7		89.4		79.1		80.0		84.1

Эх сурвалж:

2013 он: "Шилжилт хөдөлгөөн ба Гуйвуулга-2016" баримтын хуудасны мэдээлэлд үндэслэсэн Дэлхийн банкны тооцоолол (www.worldbank.org/prospects/migrationandremittances)

2017 он: НҮБ-ын Хүн амын хэлтэс, Австрали, Герман, Английн статистикийн хороонууд, АНУ-ын тооллогын товчооны мэдээлэлд үндэслэсэн Дэлхийн банкны тооцоо

2010, 2020: ҮСХ-ны 2010 оны ХАОСТ-ын үр дүнд үндэслэсэн өөрийн тооцоо

2016: ГХЯ-ны консулын газруудын мэдээлэлд үндэслэсэн өөрийн тооцоо

4. ДҮГНЭЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хүн амын гадаад шилжилт хөдөлгөөнийг удирдах талаар баримталж буй улс орнуудын байр суурь, бодлого нь гадаад шилжилт хөдөлгөөний түвшин, чиг хандлагад шууд нөлөөлдөг. НҮБ-ын мэдээллээр 2015 оны байдлаар 196 улсын 61 хувь нь гадаадаас шилжин ирэлт-ийн одоогийн түвшинг хэвээр "үргэлжлүүлэх", 12 хувь нь "эсгөх", 13 хувь нь "бууруулах" бодлого баримталсан байхад үлдсэн 14 хувь нь шилжин ирэлтийн талаар албан ёсны "бодлогогүй" буюу түүнд нөлөөлөх оролдлого хийгээгүй байна (UN DESA, PA, 2016). Давхардсан тоогоор, гадаадаас шилжин ирэлтийг нэмэгдүүлэх бодлоготой орнуудын 68 хувь нь эдийн засгийн тодорхой салбарт хөдөлмөрийн хангагдаагүй эрэлтийг хангах, 46 хувь нь улсынхаа иргэдийн ажил эрхлэх боломжийг дэмжихийн тулд, 15 хувь нь хүн амын насжилтын асуудлын улмаас, 13 хувь нь хүн амын тооны бууралтын эсрэг арга хэмжээ болгож уг бодлогыг хэрэгжүүлж байна. Шилжин ирэлтийг дэмжихдээ, дэлхийн бүх бүс нутгуудад өндөр ур чадвартай шилжин ирэгчдийг илүүтэй сонирхох болсон

ба ийм ажилчдыг нэмэгдүүлэх бодлоготой орнууд 2005-аас 2015 он хооронд хоёр дахин нэмэгдэж 44 хувьд хүрчээ (UN DESA, PD, 2016). Харин гадаадад шилжин явалт-ын талаар улс орнуудын бодлогын байр суурь харьцангуй тодорхойгүй байна. Тухайлбал, 2015 оны байдлаар дэлхийн улс орнуудын 36 хувь нь хүн амын гадагш шилжих хөдөлгөөнд нөлөөлөх талаар "тодорхой бодлогогүй", 23 хувь нь одоогийн түвшинг "хэвээр үргэлжлүүлэх", 32 хувь нь "бууруулах", 9 хувь нь "нэмэгдүүлэх" бодлоготой байв.

Гадаадад гарсан иргэд эх орондоо буцаж ирэх нь капитал, технологийн болон мэдлэг, ур чадварын шилжүүлгийг уугуул орондоо авчран, хөгжилд эерэг үр нөлөөг үзүүлдэг тул улс орнууд гадаадад шилжсэн шилжигчдээ буцаан татах чиглэлийн бодлогыг ч чухалчилдаг. НҮБ-ын мэдээллээр, 2015 оны байдлаар нийт 196 орны 72 хувь нь гадаадад гарсан иргэдээ буцаж ирэхийг дэмжих, урамшуулах тусгайлсан бодлого, хөтөлбөрүүдийг гаргасан байдаг (UN DESA, PD, 2016).

Монгол Улс бодлогын хувьд гадаадын иргэдийн шилжин ирэх хөдөлгөөнд тийм ч нээлттэй биш, харин гадаадад байгаа иргэдээ эргүүлэн татах сонирхолтой оронд тооцогдохоор байна. Тодруулбал, Монгол Улс гадаад шилжилт хөдөлгөөнтэй холбоотой олон улсын гол гэрээ конвенцуудаас дүрвэгчид, шилжигч ажилчидтай холбоотой конвенцид²⁵ нэгдэн ороогүй ба 2000 оны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх конвенцид 2008 онд, 2000 оны Шилжигчдийг хил давуулан наймаалахын эсрэг протоколд 2008 онд л элсэн орсон байна. Шилжигчид хүлээн авахдаа өндөр ур чадвартай ажилчид болон тодорхой салбар дахь хөдөлмөрийн хангагдаагүй эрэлтийг нөхөх чиглэлээр л гадаадаас ажилчин авдаг²⁶, мөн гадаадын иргэнд хувийн хэргээр оршин суух, цагаачлах эрх олгохыг хатуу шалгуур²⁷, квоттойгоор зөвшөөрдөг. Тухайлбал, Гадаадын иргэний эрх зүй байдлын тухай хууль (2010)-ийн 27.4 болон 29.5-р зүйлүүдэд зааснаар, Монгол Улсын нутаг дэвсгэрт хувийн хэргээр болон цагаачлан оршин сууж болох гадаадын иргэдийн тооны квотыг Засгийн газар, УИХ-аас тогтоон хянадаг²⁸. Түүнчлэн гадаадаас авах ажиллах хүчний тооны квотыг Засгийн газраас жил бүр тогтоон УИХ-аар батлуулахдаа сүүлийн жилүүдэд багасгасаар ирсэн байна.

Иргэдийнхээ гадагш чиглэсэн шилжилтийн түвшинг Монгол Улсын Засгийн газар 2000-

аад оноос “хэт өндөр” гэж үзэх болсон²⁹. Үүнтэй холбоотойгоор гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэддээ эх орондоо эргэн ирж ажиллаж, амьдрах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлэх; улсынхаа хөгжилд хувь нэмрээ оруулахыг нь дэмжих; гадаадад төрж тухайн улсын иргэний харьяалалтай болсон иргэд, тэдний үр хүүхдэд Монгол Улсад зорчих, оршин суух, суралцах, ажиллаж амьдрах, даатгалд хамрагдах таатай нөхцлийг бүрдүүлэх зэрэг агуулгатай заалтуудыг бодлогын баримт бичгүүддээ³⁰ зааж, тодорхой хөтөлбөрүүд³¹ ч гаргасан байдаг. Гэвч гадаадад шилжсэн Монгол Улсын иргэдийн буцах шилжилт хөдөлгөөнийг дэмжих бодлогын хэрэгжилт тийм ч амжилттай байж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл “байнгын” болон “түр” гадаад цэвэр шилжилтүүд дандаа “хасах” утгатай, гадаадад амьдрах монгол иргэдийн нийт хүн амд эзлэх хувь буурахгүй, ид хөдөлмөрийн насны, боловсрол өндөртэй хүмүүс “байнгын” шилжин явах хөдөлгөөнд их оролцох хандлагууд сүүлийн 30-аад жилд хэвээр байсаар байна. Энэ нь гадаадад байгаа иргэдээ эх орондоо эргэн ирэх таатай нөхцөл бүрдүүлэх, эсвэл гадаадад амьдрангаа эх орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах боломж, санаачлагуудыг нь урамшуулж дэмжих бодьтой, дорвитой үйл ажиллагаанууд хийгдэж чадахгүй байгаатай холбоотой болов уу. Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг Дэлхийн Өрсөлдөх чадварын судалгаа 2015-2016-д дурьдсанаар Монгол Улс гадаадаас “авъяаслаг” иргэдийг эх орондоо татах чадварын үнэлгээ³²-ээр 104-р байрт, “авъяаслаг” иргэдээ гадагш алдахгүй, тогтоох чадварын үнэлгээ³³-ээр дэлхийн 140 орноос 112-р байрт эрэмбэлэгдсэн байгаа

²⁵ “Цагаач ажилчид ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах” тухай НҮБ-ын конвенц

²⁶ Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль (2001)-иар мэргэжлийн өндөр ур чадвар шаардах ажил, мэргэжлээр болон улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга байгууламж барих, гамшгийн хор уршгийг арилгахад шаардагдах ажиллах хүчийг дотоодоос хангах бололцоогүй үед гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахаар заасан байдаг (уг хуулинд 2006, 2008, 2011, 2012, 2015, 2016, 2017 онуудад нэмэлт өөрчлөлт орсон). Энэ хуулиас гадна гадаад шилжих хөдөлгөөнийг зохицуулах, удирдах, тоо мэдээллийг бүртгэх чиглэлээр *Монгол улсын үндсэн хууль* (1992), *Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай* (1997, 1999, 2000, 2008, 2011, 2013, 2015, 2016, 2017, 2018 онуудад нэмэлт өөрчлөлт орсон), *Гадаадын иргэний эрх зүй байдлын тухай* (2010), *Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль* (2008) зэргийг батлан мөрдөж байгаа.

²⁷ ГИХГ-ын мэдээллээр, дээд боловсролтой, амьжиргааны түвшин нь хөдөлмөрийн хөдөлгөөнд доод хэмжээнээс 5 дахин их, гэмт хэрэгт ял шийтгэгдээгүй, ХДХВ/ДОХ зэрэг халдварт өвчнөөр өвчлөөгүй, Монгол улсад 5-аас дээш жил амьдарсан байх гэх мэт шалгуурыг хангасан иргэнд цагаачлах эрх олгодог.

²⁸ Хувийн хэргээр оршин суух гадаадын иргэдийн тоо Монгол Улсын харъяат хүн амын 3 хувь, үүний дотор нэг улсын иргэн нэг хувь хүртэл; цагаачлан оршин суух иргэдийн тоо 0.5 хувь, үүний дотор нэг улсын иргэн 0.17 хувь хүртэл байж болно гэж заасан байдаг.

²⁹ НҮБ-ын НЭЗХ-ээс Засгийн газруудын байр суурийг тодорхойлох асуулгын дагуу цуглуулсан мэдээллийн үр дүн.

³⁰ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010); Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал (2011); Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2004-2015); Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025).

³¹ Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2012-2016, 2016-2020 оны хөтөлбөрүүд, “Зөгийн үүр” хөтөлбөр (2012-2016), “Дэлхийн монголчууд” хөтөлбөр (2016-2020), Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр (4 жил тутам тодотгосон төлөвлөгөөтэй хэрэгжих заалттай), Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр (2008-2012).

³² 1-7 хүртэл оноотой индексээр хэмждэг ба ААНБ-аас авсан түүвэр судалгаагаар дүгнэдэг. Үүнээс гадна тухайн орон дахь гадаад иргэдийн тоо, гадаад оюутнуудын тоо, орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаадын эзэмшигч, өмчлөгчтэй компаниуд зэрэг мэдээллүүдээр “гадаадын сонирхлыг татах” чадварыг ерөнхийлөн гаргадаг.

³³ 1-7 хүртэл оноотой индексээр хэмждэг ба ААНБ-аас авсан түүвэр судалгаагаар дүгнэдэг.

нь оюунлаг, чадварлаг иргэдээ гадагш алдах орныхоо хөгжилд оролцуулахад хүндрэл их өндөр эрсдэлтэй, мөн гадаадад байгаа байгааг баталж байна. чадварлаг иргэдээ буцаан татах юмуу эх

ХҮЛЭЭН АВАГЧ ОРНЫ ХИЛЭЭР НЭВТЭРСЭН ИРГЭДИЙН НЭРШИЛ, ТОДОРХОЙЛОЛТУУД

А. Гадаад шилжилт хөдөлгөөнд тооцогдохгүй, дамжин өнгөрөх хөдөлгөөнд оролцогчид:

1. Хилийн бүсэд ажиллагч иргэд: Хөрш оронд ажиллахаар тодорхой зөвшөөрлийн дагуу тогтмол богино хугацаагаар хилээр орж, гардаг иргэд.
2. Хилээр дамжин өнгөрөх гадаад, дотоодын иргэд: Хил дээр түр буудалласан ч хилийн дотогш орохгүй иргэд.

Б. Олон улсын аялал жуулчлалд хамаарах хөдөлгөөнд оролцогчид:

3. Гадаадын өдрийн аялагчид: Очсон улсдаа ямар нэгэн байранд байрлаж хонохгүйгээр буцахаар хил нэвтэрсэн гадаадын иргэд буюу далайн, галт тэрэгний, газрын тээврийн тээвэрчид болон зорчигчид, мөн хөрш орноос худалдаа хийх, танил, хамаатныдаа зочлох, эмнэлгийн үйлчилгээ авах, амралт зугаалгын зорилгоор өдрөөр хил нэвтэрсэн хүмүүс гэх мэт.
4. Гадаадын жуулчид: Амрах, аялах, зугаалах, найз нөхөд хамаатныдаа зочлох, эрүүл мэндийн үйлчилгээ авах, шашны зан үйлд оролцох зэрэг зорилгоор, шаардлагатай тохиолдолд жуулчны виз аван хил нэвтэрсэн гадаадын иргэд.
5. Албан ажлаар аялж буй гадаадын аялагчид: Цалин хөлс нь очсон улсаасаа биш, явсан улсаас олгогдох бизнесийн юмуу мэргэжлийн үйл ажиллагаанд оролцох зөвшөөрөл бүхий хил давсан гадаадын иргэн. Тэдний очсон улсдаа байх хугацаа нь хязгаартай, 12 сараас хэтрэхгүй байх.

В. Гадаад шилжилт хөдөлгөөний статистикаас уламжлалт байдлаар хасагдаж тооцогддог хөдөлгөөнд оролцогчид:

6. Гадаад дахь дипломат болон консулын төлөөлөгчид, тэднийг дагалдах гэр бүлийн гишүүд, ажилчид: Дипломат виз, зөвшөөрлийн дагуу хил нэвтэрсэн гадаадын иргэд, тэднийг дагалдан яваа хүмүүс.
7. Цэрэг, батлан хамгаалахын албаны төлөөлөгчид, тэднийг дагалдах гэр бүлийн гишүүд, ажилчид: Цэрэг, батлан хамгаалахад үйлчилгээ үзүүлэхээр хил давсан гадаадын мэргэжилтнүүд, тэднийг дагалдан яваа хүмүүс.
8. Нүүдэлчин иргэд: Нэг газраас нөгөөд нүүдэллэн амьдардаг, тогтсон нэг оршин суух газаргүй иргэд. Тэдний нүүдэл заримдаа хил давсан тохиолдолд шилжилт хөдөлгөөний flow буюу урсгалд бүртгэгддэг.

Г. Гадаад шилжилт хөдөлгөөний статистикт тооцогдох хөдөлгөөнд оролцогчид:

9. Гадаадад суралцагчид: Хүлээн авагч орны хүлээн зөвшөөрөгдсөн сургуульд суралцахаар зөвшөөрөл, виз аван хил нэвтрэгчид. Хэрэв тэдний гэр бүлийн гишүүдэд нь дагалдах эрх олгогдсон бол мөн энэ ангилалд оруулна.
10. Гадаадад дадлагажигчид: Очсон улсаас нь цалин хөлс олгогдох ажлын дадлага гүйцэтгэхээр тусгай зөвшөөрөл болон виз авч хил нэвтрэгчид. Хэрэв гэр бүлийн гишүүдэд нь дагалдах эрх олгогдсон бол мөн энэ ангилалд оруулна.
11. Гадаадын шилжигч ажилчид: Очсон улсаас нь цалин хөлс олгогдох эдийн засгийн үйл ажиллагаа гүйцэтгэх зорилгоор хүлээн авагч орноос зөвшөөрөл аван хил нэвтэрсэн гадаадын иргэд. Тэдний очсон улсдаа байх хугацаа нь ихэвчлэн ажлын байрны төрлөөсөө хамааран хязгаартай буюу түр хугацаатай байдаг. Хэрэв гэр бүлийн гишүүдэд нь дагалдах эрх олгогдсон бол мөн энэ ангилалд оруулна.
12. Гадаад дахь олон улсын байгууллагад ажиллагчид: Хүлээн авагч орны газар нутагт байрлах олон улсын байгууллагын ажилтнаар ажиллахын тулд байнга оршин суух зөвшөөрөл юмуу тусгай виз аван хил нэвтэрсэн иргэд. Хэрэв тэдний гэр бүлийн гишүүдэд нь дагалдах эрх олгогдсон бол мөн энэ ангилалд оруулна.
13. Визгүйгээр зорчих эрхтэй гадаадын иргэд: Илгээгч ба хүлээн авагч 2 улсын хоорондын тусгай гэрээ, хэлэлцээрийн дагуу хүлээн авагч оронд чөлөөтэй оршин суух эрхээ хэрэгжүүлж буй гадаадын иргэд.
14. Байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд: Оршин суух хугацаа болон эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох боломжийн хувьд гадаадын иргэнд тавигддаг ямар нэг хязгаарлалтгүйгээр хүлээн авагч оронд амьдарч, оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэд. Хэрэв тэдний гэр бүлийн гишүүдэд нь дагалдах эрх олгогдсон бол мөн энэ ангилалд оруулна.

15. Гадаадад гэр бүл үүсгэх, гадаад дахь гэр бүлээ дагалдах/нэгдэхээр явсан иргэд: Хүлээн авагч орны иргэнтэй гэрлэх гэж буй гадаадын иргэн, иргэдийн гадаадаас өргөж авсан хүүхдүүд, хүлээн авагч оронд байнга оршин сууж буй гадаадын иргэний гадаад нөхөр/эхнэр, хүлээн авагч оронд байнга оршин сууж буй ойрын хамаатныдаа хамт байхаар зөвшөөрөл аван хил нэвтэрсэн бүх гадаадын иргэд.
16. Дүрвэгчид: Хил нэвтрэхээс өмнө юмуу нэвтрэх үеэр цагаачлалын эрх авсан гадаадын иргэн. Үүнд, гадаадад байхдаа юмуу хил нэвтрэх үедээ хүлээн авагч оронд оршин суух цагаачийн эрх авсан гадаадын хүн, мөн хүлээн авагч оронд ирээд бүлгээрээ цагаачийн статус авсан хүмүүс орно. Зарим тохиолдолд төрөлх улсаасаа гадаадад цагаачлах хүсэлтээ гарган шалгуулж, эх орондоо байхдаа гадаадад цагаачлах эрх авч болдог. Ерөнхийдөө цагаачлалын статусыг Дүрвэгчдийн статусын талаарх 1951 оны гэрээгээр, хүмүүнлэгийн шалтгаанаар олгодог.

Д. Гадаад шилжилт хөдөлгөөнд тооцогдож болохоор боловч хүлээн авагч улсад байх хугацаа нь тодорхойгүй, хил нэвтрэх хөдөлгөөнд ороцогчид:

17. Орогнол хүсэгчид: Орогнол хүссэн өргөдөл гаргах зөвшөөрөл авсан, ийм өргөдөл гаргаагүй ч төрөлх улсаа аюулгүй буцталаа түр байх зөвшөөрөл авсан буюу түр хамгаалалтад орсон гадаадын иргэд.
18. Зөвшөөрөлгүй хил нэвтэрсэн эсвэл зөвшөөрөлгүй оршин суугч гадаадын иргэд: Хүлээн авагч орны шаарддаг хил нэвтрэх дүрмийг зөрчин хил нэвтэрсэн гадаадын иргэд, орогнол хайхаар оролдож буй ч зохих өргөдлийн зөвшөөрөл авч чадаагүй, хүлээн авагч оронд оршин суух/байх зөвшөөрөлгүйгээр оршин сууж байгаа гадаадын иргэд³⁴.

Эх сурвалж: *United Nations, Treaty Series, Vol. 189, No. 2545*

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэлээр:

Монгол Улсын Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль

Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүй байдлын тухай хууль

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль

Монгол Улсын Үндсэн хууль

Монгол Улсын Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал (2011)

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)

Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр (2008-2012)

Монгол Улсын Засгийн Газар, “Зөгийн үүр” хөтөлбөр (2012-2016)

Монгол Улсын Засгийн Газар, “Дэлхийн монголчууд” хөтөлбөр (2016-2020)

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2012-2016, 2016-2020 оны хөтөлбөрүүд

Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр

Болормаа.Ц (2019). “Монгол Улс: Ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөн”, *Монголын хүн амын сэтгүүл*, дугаар (499), 29, 2019, 9-18-р тал

Гэрэлчулуун.Х (2011). *Хүн амын шилжих хөдөлгөөн/Олон улсын эрх зүйн зохицуулалт*, Улаанбаатар: Мөнхийн үсэг

Жандос.С (2014). *Монгол улсын хөдөлмөрийн гадаад шилжих хөдөлгөөнийг боловсронгуй болгох нь*, магистрын зэрэг горилсон дипломын ажил

Монголбанк (2012). Гадаадад суралцаж буй монгол иргэдийн зардлын түүвэр судалгааны хураангуй тайлан (<https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group8/8-10.pdf>)

Монголбанк (2013). БНЧУ-дажиллаж, амьдарч буй монгол иргэдийн мөнгөн гуйвуулгын хэмжээг тооцоолох түүвэр судалгаа (<https://www.mongolbank.mn/documents/>)

³⁴ 1-7 хүртэл оноотой индексээр хэмждэг ба ААНБ-аас авсан түүвэр судалгаагаар дүгнэдэг.

- [statistic/externalsector/samplesurvey/BOPCzech.pdf](#))
- Монголбанк (2014). Монгол улсад ажиллаж буй гадаад ажилтнуудын цалингийн судалгаа (https://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/samplesurvey/salary_foreign.pdf)
- МХАХН, НХХЯ, НҮБХАС (2005). Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар судалгааны тайлан, Улаанбаатар
- Намуундолгион.Н (2015). *Олон улсын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн ба Монгол Улс*, магистрын судалгааны ажил
- Одмаа.С (2016). *Монголын хөдөлмөрийн зах зээл дэх олон улсын шилжилт хөдөлгөөн* магистрын судалгаа
- ОУХБ (2004). Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөний бодлого ба менежмент: Сургалтын модулиуд (орчуулгын ном), Улаанбаатар: “ADMARKET” ХХК
- Өлзийлхам.Э (2016). *Иргэдийн гадаад шилжих хөдөлгөөн Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь* диссертацийн ажил
- Солонго.А (2011). “Гадаадад ажил эрхлэхийн төлөөх шилжих хөдөлгөөн: Хүн ам зүйн тулгамдсан асуудлууд”, *Монголын хүн амын сэтгүүл*, дугаар (367) 20, 2011, 48-52-р тал
- Солонго.А (2012). “Шилжигч ажилчид: Хууль эрх зүйн орчин ба нийгэм эдийн засгийн үр нөлөө”, *Монголын хүн амын сэтгүүл*, дугаар (379) 21, 2012, 9-24
- Солонго.Т (2010). *Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний талаар олон улсын болон Монгол Улсын эрх зүйн зохицуулалт*, магистрын судалгааны ажил
- Увш.П (2011). “Гадаад дахь монгол гэр бүлийн өнөөгийн байдал, хандлага”, *Даяаршлын үеийн соёл ба миграци*, ШУТИС, Нийгмийн технологийн сургуулийн Олон улсын онол, практикийн 6-р бага хурлын эмхэтгэл, Улаанбаатар
- ҮСХ (2011а). Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Нэгдсэн дүн, Улаанбаатар
- ҮСХ (2011б). Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Гадаадад оршин суугаа Монгол улсын иргэд (сэдэвчилсэн судалгаа №13), Улаанбаатар
- ҮСХ (2011в). *Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого: Шилжих хөдөлгөөн, суурьшил* (сэдэвчилсэн судалгаа №2), Улаанбаатар
- ҮСХ (2013а). Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал (ҮСХ-ны даргын 2013 оны 12-р сарын 25-ны өдрийн 1/149 тоот тушаалын хавсралт)
- ҮСХ (2019). *Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2018*. Улаанбаатар
- ҮСХ (2020). *Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн*, Улаанбаатар: Би Си Ай
- ХНХЯ (2017). Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын судалгаа
- ХНХСИ (2016а). БНСУ, Япон улсад хөдөлмөр эрхэлж буй болон эх орондоо эргэн ирсэн иргэдийн нөхцөл байдлын судалгаа (дотоод хэрэгцээнд зориулан бэлтгэсэн тайлан)
- ХНХСИ (2016б). Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний өнөөгийн нөхцөл байдалд хийсэн баримт бичгийн шинжилгээ (дотоод хэрэгцээнд зориулан бэлтгэсэн тайлан)
- ХНХЯ, ХНХСИ (2016). Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний нөхцөл байдлын судалгаа (дотоод хэрэгцээнд зориулан бэлтгэсэн тайлан)
- Хууль зүйн үндэсний хүрээлэн (2018). Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ *судалгааны тайлан*, Улаанбаатар
- ХХССТ, ХНХЯ, НҮБХАС (2017). Гадаад шилжих хөдөлгөөний тоон ба чанарын судалгаа (ХНХЯ-ны дотоод хэрэгцээнд байгаа хэвлэгдээгүй тайлан)
- “Хэвлэлийн хүрээлэн” ТББ, НЗХГ (2018). Гадаадад сурч, боловсрол эзэмшсэн залуучуудын судалгаа (http://youth.ub.gov.mn/wp-content/uploads/2019/01/Tailan-HX3Г_Гадаадад-төгсөгчдийн-судалгаа.pdf)

- ХЭҮК (2007). “БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн зарим эрхийн хэрэгжилт” судалгааны тайлан (<http://upr-mongolia.mn/images/xupld/Migrantsfinal.pdf>)
- Цогзолмаа.Т (2017). *Шилжилт хөдөлгөөний олон улсын эрх зүйн зохицуулалт*, магистрын судалгааны ажил
- Англи хэлээр:**
- Abel & Sander (2014). “Quantifying global international migration flows”. *Science*, 343 (6178).
- IBRD, World Bank (2006). *Global Economic Prospects: Economic Implications of Remittances and Migration*. USA: Washington DC
- IILS (2004). *Migration and development: Toward sustainable solutions (discussion paper DP/153/2004)*, Switzerland: Geneva. (https://www.ilo.org/wcmsp5/groups/public/dgreports/inst/documents/publication/wcms_193625.pdf).
- IMF (2009). *Balance of Payments and International Investment Position Manual*, sixth edition (BPM6), IMF Multimedia Services Division (www.imfbookstore.org)
- INSEAD (2015). “International mobility and talent attraction: a research commentary”, *The global talent competitiveness index 2015-2016* (ed. Bruno Lanvin and Paul Evans), Fontainebleau, France
- IOM (2017). *World migration report 2018*. Switzerland
- IOM (2019a). *World migration report 2020*. Switzerland (<http://www.iom.int/wmr>)
- IOM (2019b). *Glossary on migration*, IML Series No. 34, 2019.
- IOM GMDAC (2018). *Global migration indicators 2018*. Germany
- Justino.P and O.Shemyakina (2012). “Remittances and labor supply in post-conflict Tajikistan”, *IZA Journal of Labor & Development*, 2012, vol. 1, issue 1, 1-28
- OECD, IOM, UNHCR (2019). *2019 International Migration and Displacements Trends and Policies Report to the G20*
- Paoli and Mendola (2016). *International Labor mobility and child work in developing countries*, IZA Discussion paper 8066, Institute of Labor Economics
- UN DESA, Population Division (2012). *Toolkit on International Migration*. (available at www.unmigration.org)
- UN DESA (2015). *Trends in International Migrant Stock: Migrants by Destination and Origin* (United Nations database, POP/DB/MIG/Stock/Rev.2015).
- UN DESA, PD (2017a). *International migration report 2017: Highlights* (ST/ESA/SER.A/404).
- UN DESA, PD (2017b). *International Migration Policies: Data Booklet*. (ST/ESA/SER.A/395).
- UN DESA, PD (2016). *World Population Policies Database: 2015 Revision*. (http://esa.un.org/poppolicy/about_database.aspx)
- UN DESA, PD (2019). *World Population Prospects 2019: Highlights* (ST/ESA/SER.A/423).
- UN DESA, Statistics Division (1998). *Recommendations on Statistics of International Migration, Revision 1. Statistical papers, Series M. No.58, Rev.1*, USA: New-York
- United Nations, *Treaty Series*, vol.189, No.2545
- Vadean.F, T.Randazzo & M.Piracha (2019). “Remittances, Labour Supply and Activity of Household Members Left-Behind”, *The Journal of Development Studies*, 55:2, 278-93, DOI: [10.1080/00220388.2017.1404031](https://doi.org/10.1080/00220388.2017.1404031)
- World Bank (2019). *Leveraging Economic Migration for Development: A Briefing for the World Bank Board*. Washington DC: World Bank